

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2024 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар 24/01

Улаанбаатар хот

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛЫГ БАТЛАХ ТУХАЙ**

“Атар-Өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

“Атар-Өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын “Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай” 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус баталсугай.

  
ХУРЛЫН ДАРГА Б.МӨНХДАЛАЙ

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2024 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар 24/02

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТУХАЙ**

“Атар-Өргөө” ХК-ийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар баталсугай.

  
ХУРЛЫН ДАРГА **Б.МӨНХДАЛАЙ**



**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар 24/04

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ӨГСӨН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

“Атар-Өргөө” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Аудитын байгууллагын дүгнэлтэнд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Аудитын байгууллагын дүгнэлтийг зөвшөөрч, баталсугай.
2. Компанийн санхүүгийн тайлангийн талаарх Аудитын байгууллагын дэвшүүлсэн саналыг хэрэгжүүлж ажиллахыг шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

  
ХУРЛЫН ДАРГА  Б.МӨНХДАЛАЙ



“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар 24/06

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР  
СОНГОГДСОНЫГ БАТАЛЖ,  
БҮРЭН ЭРХИЙГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, компанийн Дүрмийн “Долоо”-ын 7.22 дахь заалт, хувьцаа эзэмшигчдээс кумулятив аргаар өгсөн санал, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Дор дурдсан хүмүүсийг “Атар-Өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталж, бүрэн эрхийг зөвшөөрсүгэй.

Үүнд:

ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

- Б.Мөнхдалай
- Б.Ганбат
- Ж.Сайнбилэг
- Г.Баттулга
- Г.Энхболд
- Л.Ганпүрэв

ТУЗ-ын хараат бус гишүүнээр:

- С.Бямбахорол
- Т.Жигмэддагва
- Г.Оюун

ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар 24/07

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН  
ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

“Атар-Өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын төсвийг батлах тухай төсвийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын зардлын төсөв”-ийг энэхүү тогтоолын 1-р хавсралтаар баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ